



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Нам хүчдэлийн цахилгаан байгууламж
7-708 дугаар хэсэг: Тусгай байгууламж буюу байршилд тавих шаардлага –
Караваны парк, кемпийн талбай болон түүнтэй адилтгах байршил**

**Low-voltage electrical installations
Part 7-708: Requirements for special installations or locations –
Caravan parks, camping parks and similar locations**

IEC 60364-7-708:2017, Edition 3.0, 2017-04

ICS 91.140.50

MNS IEC 60364-7-708:20XX

**Албан хэвлэл
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Улаанбаатар хот
20XX он**

MNS IEC 60364-7-708:20XX

Энэ стандартыг орчуулж,
..... шүүмж, редакц хийж, хянасан.
Анхны үзлэгийг 20XX онд, дараа нь 5 жил тутамд хийнэ.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Шуудангийн хаяг: Улаанбаатар-13343, Ш/Х - 48

Утас: 976-51-263860

E-mail: standardinform@masm.gov.mn

www.estandard.gov.mn; www.masm.gov.mn

© СХЗГ, 20XX

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай”
Монгол Улсын хууль болон холбогдох эрх зүйн зохицуулалтын дагуу энэхүү стандартыг
бүрэн эсхүл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь стандартчиллын төв байгууллагад
байна.

АГУУЛГА / CONTENTS

МОНГОЛ	ENGLISH
ӨМНӨХ ҮГ	FOREWORD
УДИРТГАЛ	INTRODUCTION
708 Караваны парк, кемпийн талбай болон түүнтэй адилтгах байршил	708 Caravan parks, camping parks and similar locations
708.1 Хамрах хүрээ	708.1 Scope
708.2 Норматив эшлэл	708.2 Normative references
708.3 Нэр томъёо ба тодорхойлолт	708.3 Terms and definitions
708.31 Зориулалт, тэжээл ба бүтэц	708.31 Purposes, supplies and structure
708.312 Дамжуулагчийн зохион байгуулалт ба системийн газардуулга	708.312 Conductor arrangement and system earthing
708.313 Тэжээл	708.313 Supplies
708.4 Аюулгүй байдлын хамгаалалт	708.4 Protection for safety
708.41 Цахилгаан гүйдэлд нэрвэгдэхээс хамгаалах	708.41 Protection against electric shock
708.415 Нэмэлт хамгаалалт	708.415 Additional protection
708.5 Цахилгаан тоног төхөөрөмжийг сонгох ба угсрах	708.5 Selection and erection of electrical equipment
708.51 Цахилгаан тоног төхөөрөмжийг сонгох ба угсрах – Нийтлэг дүрэм	708.51 Selection and erection of electrical equipment – Common rules
708.512 Ажлын нөхцөл ба гадаад нөлөөлөл	708.512 Operational conditions and external influences
708.52 Утас, кабелийн систем	708.52 Wiring systems
708.521 Утас, кабелийн системийн төрөл	708.521 Types of wiring systems
708.533 Хэт гүйдлээс хамгаалах төхөөрөмж	708.533 Devices for protection against overcurrent
708.536 Тусгаарлалт ба сэлгэн залгалт	708.536 Isolation and switching
708.55 Бусад тоног төхөөрөмж	708.55 Other equipment
А хавсралт (мэдээллийн) – Зарим улсын тухай тайлбарын жагсаалт	Annex A (informative) – List of notes concerning certain countries
НОМ ЗҮИ	Bibliography

НАМ ХҮЧДЭЛИЙН ЦАХИЛГААН БАЙГУУЛАМЖ –

**7-708 дугаар хэсэг: Тусгай байгууламж буюу байршилд тавих шаардлага –
Караваны парк, кемпийн талбай болон түүнтэй адилтгах байршил**

ӨМНӨХ ҮГ

1) Олон Улсын Цахилгаан Техникийн Комисс (IEC) нь үндэсний цахилгаан техникийн бүх хороодоос (IEC-ийн Үндэсний хороод) бүрдсэн дэлхий нийтийн стандартчиллын байгууллага юм. IEC-ийн зорилго нь цахилгаан ба электроникийн салбарын стандартчилалтай холбоотой бүх асуудлаар олон улсын хамтын ажиллагааг дэмжихэд оршино. Энэ зорилгын хүрээнд болон бусад үйл ажиллагааны зэрэгцээ IEC нь Олон улсын стандарт, Техникийн тодорхойлолт, Техникийн тайлан, Нийтэд нээлттэй тодорхойлолт (PAS) болон гарын авлага (цаашид “IEC-ийн хэвлэл(үүд)” гэх)-ыг нийтэлдэг. Тэдгээрийг боловсруулах ажлыг техникийн хороод гүйцэтгэх бөгөөд тухайн сэдвийг сонирхсон IEC-ийн аливаа Үндэсний хороо бэлтгэл ажилд оролцож болно. IEC-тэй хамтран ажилладаг олон улсын, төрийн болон төрийн бус байгууллагууд мөн бэлтгэл ажилд оролцоно. IEC нь хоёр байгууллагын хооронд тохиролцсон нөхцөлийн дагуу Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-тай нягт хамтран ажилладаг.

2) Техникийн хороо бүрд тухайн сэдвийг сонирхсон IEC-ийн бүх Үндэсний хороод төлөөлөлтэй оролцдог тул техникийн асуудлаарх IEC-ийн албан ёсны шийдвэр буюу хэлэлцээр нь холбогдох сэдвийн талаарх олон улсын саналын зөвшилцлийг боломжит хэмжээнд илэрхийлдэг.

3) IEC-ийн хэвлэлүүд нь олон улсын хэрэглээнд зориулсан зөвлөмжийн хэлбэртэй бөгөөд IEC-ийн Үндэсний хороод тэдгээрийг энэ утгаар хүлээн зөвшөөрдөг. IEC-ийн хэвлэлийн техникийн агуулгыг үнэн зөв байлгахын тулд боломжит бүх хүчин чармайлт гаргадаг боловч тэдгээрийг хэрхэн ашигласан, эсхүл эцсийн хэрэглэгч буруу тайлбарласны төлөө IEC хариуцлага хүлээхгүй.

4) Олон улсын нэг мөр байдлыг дэмжихийн тулд IEC-ийн Үндэсний хороод IEC-ийн хэвлэлийг үндэсний болон бүс нутгийн хэвлэлдээ боломжит хамгийн их хэмжээгээр ил тод тусган хэрэглэх үүрэг хүлээнэ. IEC-ийн хэвлэл болон түүнд харгалзах үндэсний буюу бүс нутгийн хэвлэлийн аливаа зөрүүг сүүлийн баримт бичигт тодорхой заана.

5) IEC өөрөө тохирлын баталгаажуулалт хийдэггүй. Хараат бус гэрчилгээжүүлэлтийн байгууллагууд тохирлын үнэлгээний үйлчилгээ үзүүлдэг бөгөөд зарим салбарт IEC-ийн тохирлын тэмдгийг ашиглах боломж олгодог. Хараат бус гэрчилгээжүүлэлтийн байгууллагын үзүүлсэн аливаа үйлчилгээний төлөө IEC хариуцлага хүлээхгүй.

6) Бүх хэрэглэгч энэхүү хэвлэлийн хамгийн сүүлийн хэвлэлийг ашиглаж байгаа эсэхээ өөрсдөө нягтлах хэрэгтэй.

7) IEC, түүний удирдлага, ажилтан, үйлчилгээ үзүүлэгч буюу төлөөлөгч, түүний дотор хувь шинжээч болон техникийн хороо, IEC-ийн Үндэсний хорооны гишүүд нь энэхүү IEC-ийн хэвлэл буюу бусад IEC-ийн хэвлэлийг нийтэлсэн, ашигласан эсхүл түүнд тулгуурласнаас үүдэн гарах хүний гэмтэл, эд хөрөнгийн хохирол болон бусад аливаа шууд буюу шууд бус хохирол, зардлын (хууль зүйн зардлыг оролцуулан) төлөө хариуцлага хүлээхгүй.

8) Энэхүү хэвлэлд эш татсан норматив баримт бичгүүдэд анхаарна. Энэхүү хэвлэлийг зөв хэрэглэхэд эш татсан хэвлэлүүдийг ашиглах нь зайлшгүй шаардлагатай.

9) Энэхүү IEC-ийн хэвлэлийн зарим бүрэлдэхүүн хэсэг патентын эрхийн зүйл байж болох боломжид анхаарна. IEC нь ийм патентын эрхийн аль нэгийг буюу бүгдийг тодорхойлох үүрэг хүлээхгүй.

ӨМНӨХ ҮГ (үргэлжлэл)

IEC 60364-7-708 Олон улсын стандартыг IEC-ийн 64 дүгээр техникийн хороо “Цахилгаан байгууламж ба цахилгаан гүйдэлд нэрвэгдэхээс хамгаалах” боловсруулсан.

Энэхүү гуравдугаар хэвлэл нь 2007 онд хэвлэгдсэн хоёрдугаар хэвлэлийг хүчингүй болгож, орлоно. Энэ хэвлэл нь техникийн шинэчилсэн найруулга болно.

Өмнөх хэвлэлтэй харьцуулахад дараах техникийн гол өөрчлөлтийг оруулсан:

– механик цохилтоос хамгаалах шаардлагыг өөрчилсөн: кемпийн талбайд суурилуулсан тоног төхөөрөмжийг одоо их хүчтэй AG3 цохилтоос хамгаалах (хамгийн багадаа IK08 хамгаалалтын зэрэг) шаардлагатай болсон;

– хүрэх боломжтой үед розеткын контакт хүчдэлтэй байхаас сэргийлэхийн тулд розетка ба холбогчийг IEC стандартын дагуу харилцан түгжээтэй байхыг шаардсан.

Энэхүү стандартын бичвэр нь 64/2162/FDIS баримт бичиг болон 64/2186/RVD санал хураалтын тайланд үндэслэсэн.

Энэхүү стандартыг батлах санал хураалтын бүрэн мэдээллийг дээр заасан санал хураалтын тайлангаас үзэж болно.

Энэхүү хэвлэлийг ISO/IEC-ийн Захирамж, 2 дугаар хэсгийн дагуу боловсруулсан.

Уншигчийн анхаарлыг А хавсралтад энэхүү стандартын сэдэвтэй холбоотой түр шинжтэй ялгаатай практикийн талаарх “зарим улсад” хамаарах бүх заалтыг жагсаасанд хандуулна.

IEC 60364 цувралын “Нам хүчдэлийн цахилгаан байгууламж” ерөнхий нэртэй бүх хэсгийн жагсаалтыг IEC-ийн цахим хуудаснаас үзэж болно.

Энэ цувралын цаашдын стандартууд дээр дурдсан шинэ ерөнхий гарчгийг хэрэглэнэ. Энэ цувралын одоо байгаа стандартуудын гарчгийг дараагийн хэвлэл гарах үед шинэчилнэ.

Хороо энэхүү хэвлэлийн агуулгыг IEC-ийн цахим хуудасны тухайн хэвлэлийн мэдээлэлд заасан тогтвортой байдлын огноо хүртэл өөрчлөхгүй байхаар шийдвэрлэсэн. Энэ огноонд хэвлэлийг дахин баталгаажуулах, хүчингүй болгох, шинэчилсэн хэвлэлээр орлуулах эсхүл нэмэлт өөрчлөлт оруулна.

Энэхүү хэвлэлийн хоёр хэлтэй хувилбарыг хожим гаргаж болно.

LOW-VOLTAGE ELECTRICAL INSTALLATIONS –

**Part 7-708: Requirements for special installations or locations – Caravan parks,
camping parks and similar locations**

FOREWORD

1) The International Electrotechnical Commission (IEC) is a worldwide organization for standardization comprising all national electrotechnical committees (IEC National Committees). The object of IEC is to promote international co-operation on all questions concerning standardization in the electrical and electronic fields. To this end and in addition to other activities, IEC publishes International Standards, Technical Specifications, Technical Reports, Publicly Available Specifications (PAS) and Guides (hereafter referred to as “IEC Publication(s)”). Their preparation is entrusted to technical committees; any IEC National Committee interested in the subject dealt with may participate in this preparatory work. International, governmental and non-governmental organizations liaising with the IEC also participate in this preparation. IEC collaborates closely with the International Organization for Standardization (ISO) in accordance with conditions determined by agreement between the two organizations.

2) The formal decisions or agreements of IEC on technical matters express, as nearly as possible, an international consensus of opinion on the relevant subjects since each technical committee has representation from all interested IEC National Committees.

3) IEC Publications have the form of recommendations for international use and are accepted by IEC National Committees in that sense. While all reasonable efforts are made to ensure that the technical content of IEC Publications is accurate, IEC cannot be held responsible for the way in which they are used or for any misinterpretation by any end user.

4) In order to promote international uniformity, IEC National Committees undertake to apply IEC Publications transparently to the maximum extent possible in their national and regional publications. Any divergence between any IEC Publication and the corresponding national or regional publication shall be clearly indicated in the latter.

5) IEC itself does not provide any attestation of conformity. Independent certification bodies provide conformity assessment services and, in some areas, access to IEC marks of conformity. IEC is not responsible for any services carried out by independent certification bodies.

6) All users should ensure that they have the latest edition of this publication.

7) No liability shall attach to IEC or its directors, employees, servants or agents including individual experts and members of its technical committees and IEC National Committees for any personal injury, property damage or other damage of any nature whatsoever, whether direct or indirect, or for costs (including legal fees) and expenses arising out of the publication, use of, or reliance upon, this IEC Publication or any other IEC Publications.

8) Attention is drawn to the Normative references cited in this publication. Use of the referenced publications is indispensable for the correct application of this publication.

9) Attention is drawn to the possibility that some of the elements of this IEC Publication may be the subject of patent rights. IEC shall not be held responsible for identifying any or all such patent rights.

FOREWORD (continued)

International Standard IEC 60364-7-708 has been prepared by IEC technical committee 64: Electrical installations and protection against electric shock.

This third edition cancels and replaces the second edition published in 2007. This edition constitutes a technical revision.

This edition includes the following significant technical changes with respect to the previous edition:

- requirements to protect against impact has changed: equipment installed in a campsite now has to be protected against impact of high severity AG3 (minimum degree of protection IK 08);
- socket outlets and connectors are now required to be interlocked in accordance with IEC standards to prevent the socket contacts being live when accessible.

The text of this standard is based on the following documents: FDIS 64/2162/FDIS; Report on voting 64/2186/RVD.

Full information on the voting for the approval of this standard can be found in the report on voting indicated in the above table.

This publication has been drafted in accordance with the ISO/IEC Directives, Part 2.

The reader's attention is drawn to the fact that Annex A lists all of the "in-some-country" clauses on differing practices of a less permanent nature relating to the subject of this standard.

A list of all parts in the IEC 60364 series, published under the general title Low-voltage electrical installations, can be found on the IEC website.

Future standards in this series will carry the new general title as cited above. Titles of existing standards in this series will be updated at the time of the next edition.

The committee has decided that the contents of this publication will remain unchanged until the stability date indicated on the IEC website under "<http://webstore.iec.ch>" in the data related to the specific publication. At this date, the publication will be reconfirmed, withdrawn, replaced by a revised edition, or amended.

A bilingual version of this publication may be issued at a later date.

МОНГОЛ	ENGLISH
УДИРТГАЛ IEC 60364-ийн энэ хэсгийн (IEC 60364-7-708) зорилгоор IEC 60364-ийн ерөнхий 1-6 дугаар хэсгийн шаардлагыг хэрэглэнэ. IEC 60364-ийн IEC 60364-7-7XX хэсгүүд нь IEC 60364-ийн ерөнхий хэсгүүдийн (IEC 60364-1-ээс IEC 60364-6) шаардлагад үндэслэсэн тусгай байгууламж буюу байршлын тусгай шаардлагыг агуулна. Эдгээр IEC 60364-7-7XX хэсгийг ерөнхий хэсгүүдийн шаардлагатай хамтатган авч үзнэ. IEC 60364-ийн энэ хэсгийн тусгай шаардлага нь энэ хэсэг хэвлэгдэх үед хүчин төгөлдөр байсан IEC 60364-ийн ерөнхий хэсгүүдийн зарим шаардлагыг нэмэлтээр тодруулж, өөрчилж эсхүл орлоно. Ерөнхий хэсгийн аль нэг хэсэг буюу зүйлийг хассан тухай эшлэл байхгүй бол ерөнхий хэсгийн тухайн заалтыг хэрэглэнэ (огноогүй эшлэл). Энэ хэсэгт хамрагдах байгууламжид хамаарах бусад 7XX хэсгийн шаардлага мөн үйлчилнэ. Иймээс энэ хэсэг нь хэвлэгдэх үед хүчин төгөлдөр байсан тэдгээр шаардлагын заримыг нэмэлтээр тодруулж, өөрчилж эсхүл орлож болно. Энэ хэсгийн зүйлүүдийн дугаарлалт нь IEC 60364-ийн бүтэц болон харгалзах эшлэлийн дугаарлалтыг дагана. Энэ хэсгийн тусгай дугаарын ард байрлах дугаарууд нь энэ баримт бичгийн норматив эшлэлд заасан, энэ хэсгийг хэвлэх үед хүчин төгөлдөр байсан IEC 60364 цувралын бусад хэсгийн харгалзах хэсэг буюу зүйлийн дугаар болно (огноотой эшлэл). IEC 60364 цувралын бусад хэсэгт байгаагаас нэмэлт шаардлага буюу тайлбар шаардлагатай бол тэдгээрийг 708.101, 708.102, 708.103 гэх мэтээр дугаарлана. Энэ хэсгийг хэвлэсний дараа дугаарлалт нь өөрчлөгдсөн шинэ буюу нэмэлт өөрчлөлттэй ерөнхий хэсгүүд хэвлэгдсэн тохиолдолд энэ 701 хэсэгт эш татсан ерөнхий хэсгийн зүйлүүдийн дугаар хамгийн сүүлийн хэвлэлтэй тохирохгүй байж болно. Огноотой эшлэлийг	INTRODUCTION For the purpose of this part (IEC 60364-7-708) the requirements of the general Parts 1 to 6 of IEC 60364 apply. The IEC 60364-7-7XX parts of IEC 60364 contain particular requirements for special installations or locations which are based on the requirements of the general parts of IEC 60364 (IEC 60364-1 to IEC 60364-6). These IEC 60364-7-7XX parts are considered in conjunction with the requirements of the general parts. The particular requirements of this part of IEC 60364 supplement, modify or replace certain of the requirements of the general parts of IEC 60364 being valid at the time of publication of this part. The absence of reference to the exclusion of a part or a clause of a general part means that the corresponding clauses of the general part are applicable (undated reference). Requirements of other 7XX parts being relevant for installations covered by this part also apply. This part may therefore also supplement, modify or replace certain of these requirements valid at the time of publication of this part. The clause numbering of this part follows the pattern and corresponding references of IEC 60364. The numbers following the particular number of this part are those of the corresponding parts, or clauses of the other parts of the IEC 60364 series, valid at the time of publication of this part, as indicated in the normative references of this document (dated reference). If requirements or explanations additional to those of the other parts of the IEC 60364 series are needed, the numbering of such items appears as 708.101, 708.102, 708.103 etc. In the case where new or amended general parts with modified numbering were published after this part was issued, the clause numbers referring to a general part in this 701 part may no longer align with the latest edition of the general part. Dated references should be observed.

МОНГОЛ	ENGLISH
баримтална.	
НАМ ХҮЧДЭЛИЙН ЦАХИЛГААН БАЙГУУЛАМЖ – 7-708 дугаар хэсэг: Тусгай байгууламж буюу байршилд тавих шаардлага – Караваны парк, кемпийн талбай болон түүнтэй адилтгах байршил	LOW-VOLTAGE ELECTRICAL INSTALLATIONS – Part 7-708: Requirements for special installations or locations – Caravan parks, camping parks and similar locations
708 Караваны парк, кемпийн талбай болон түүнтэй адилтгах байршил	708 Caravan parks, camping parks and similar locations
708.1 Хамрах хүрээ IEC 60364-ийн энэ хэсгийн тусгай шаардлага нь зөвхөн караваны парк, кемпийн талбай болон түүнтэй адилтгах байршилд амралт, зугаалгын зориулалттай сууцны тээврийн хэрэгсэл, майхан эсхүл сууцны паркийн зөөврийн сууцыг тэжээх зориулалттай хэлхээнд хамаарна. <i>ТАЙЛБАР – Энэ баримт бичгийн зорилгоор “караваны парк” гэдэгт кемпийн талбай болон түүнтэй адилтгах байршилыг мөн хамруулна.</i> Эдгээр тусгай шаардлага нь амралт, зугаалгын зориулалттай сууцны тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт буюу зөөвөрлөх нэгж эсхүл сууцны паркийн зөөврийн сууцны дотоод цахилгаан байгууламжид хамаарахгүй.	708.1 Scope The particular requirements contained in this part of IEC 60364 apply only to circuits intended to supply leisure accommodation vehicles, tents or residential park homes in caravan parks, camping parks and similar locations. <i>NOTE For the purposes of this document caravan park includes camping parks and similar locations.</i> The particular requirements do not apply to the internal electrical installations of leisure accommodation vehicles, mobile or transportable units or residential park homes.
708.2 Норматив эшлэл Дараах баримт бичгүүдийг энэ баримт бичгийн бичвэрт тэдгээрийн агуулгын зарим эсхүл бүх хэсэг нь энэхүү баримт бичгийн шаардлага болох байдлаар эш татсан. Огноотой эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Огноогүй эшлэлийн хувьд эш татсан баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэлийг (түүний бүх нэмэлт өөрчлөлтийг оролцуулан) хэрэглэнэ. IEC 60038, IEC стандартын хүчдэлүүд IEC 60309-1:1999, Үйлдвэрлэлийн зориулалтын залгуур, розетка ба холбогч – 1 дүгээр хэсэг: Ерөнхий шаардлага; IEC 60309-1:1999/AMD1:2005; IEC 60309-	708.2 Normative references The following documents are referred to in the text in such a way that some or all of their content constitutes requirements of this document. For dated references, only the edition cited applies. For undated references, the latest edition of the referenced document (including any amendments) applies. IEC 60038, IEC standard voltages IEC 60309-1:1999, Plugs, socket-outlets and couplers for industrial purposes – Part 1: General requirements; IEC 60309-1:1999/AMD1:2005; IEC 60309-1:1999/AMD2:2012 IEC 60309-2, Plugs, socket-outlets and couplers for industrial purposes – Part 2:

МОНГОЛ	ENGLISH
1:1999/AMD2:2012 IEC 60309-2, Үйлдвэрлэлийн зориулалтын залгуур, розетка ба холбогч – 2 дугаар хэсэг: Шонтой болон контакт-хоолойт хэрэгслийн хэмжээсийн харилцан солилцох чадварын шаардлага IEC 60309-4:2006, Үйлдвэрлэлийн зориулалтын залгуур, розетка ба холбогч – 4 дүгээр хэсэг: Харилцан түгжээтэй эсхүл түгжээгүй сэлгэн залгах розетка ба холбогч; IEC 60309-4:2006/AMD1:2012 IEC 60364-4-43, Нам хүчдэлийн цахилгаан байгууламж – 4-43 дугаар хэсэг: Аюулгүй байдлын хамгаалалт – Хэт гүйдлээс хамгаалах IEC 62262, Цахилгаан тоног төхөөрөмжийн бүрхүүлээс гадаад механик үйлчлэлийн эсрэг хангах хамгаалалтын зэрэг (IK код)	Dimensional interchangeability requirements for pin and contact-tubes accessories IEC 60309-4:2006, Plugs, socket-outlets and couplers for industrial purposes – Part 4: Switched socket-outlets and connectors with or without interlock; IEC 60309-4:2006/AMD1:2012 IEC 60364-4-43, Low-voltage electrical installations – Part 4-43: Protection for safety – Protection against overcurrent IEC 62262, Degrees of protection provided by enclosures for electrical equipment against external mechanical impacts (IK code)
708.3 Нэр томьёо ба тодорхойлолт Энэ баримт бичгийн зорилгоор дараах нэр томьёо ба тодорхойлолтыг хэрэглэнэ. ISO болон IEC нь стандартчилалд ашиглах нэр томьёоны мэдээллийн санг хөтөлдөг.	708.3 Terms and definitions For the purposes of this document, the following terms and definitions apply. ISO and IEC maintain terminological databases for use in standardization at the following addresses: • IEC Electropedia: available at http://www.electropedia.org/ • ISO Online browsing platform: available at http://www.iso.org/obp
708.3.1 амралт, зугаалгын зориулалттай сууцны тээврийн хэрэгсэл түр буюу улирлын чанартай оршин суух зориулалтын сууцны нэгж бөгөөд авто замын тээврийн хэрэгслийн хийц ба ашиглалтын шаардлагыг хангаж болох нэгж	708.3.1 leisure accommodation vehicle unit of living accommodation for temporary or seasonal occupation that may meet the requirements for the construction and use of road vehicles
708.3.1.1 караван аялалд ашигладаг, авто замын тээврийн хэрэгслийн хийц ба ашиглалтын шаардлагыг хангасан чиргүүлт амралт, зугаалгын зориулалттай сууцны тээврийн хэрэгсэл	708.3.1.1 caravan trailer leisure accommodation vehicle, used for touring, that meets the requirements for the construction and use of road vehicles

МОНГОЛ	ENGLISH
708.3.1.2 авто караван аялалд ашигладаг, авто замын тээврийн хэрэгслийн хийц ба ашиглалтын шаардлагыг хангасан өөрөө явагч амралт, зугаалгын зориулалттай сууцны тээврийн хэрэгсэл <i>Бичилтийн 1-р тайлбар: Авто караван нь цувралаар үйлдвэрлэсэн тээврийн хэрэгслийг өөрчлөн тоногловсон, эсхүл жолоочийн бүхээгтэй буюу бүхээггүй одоо байгаа явах эд анги дээр зураг төсөл зохион үйлдвэрлэсэн байж болох бөгөөд сууцны хэсэг нь суурин эсхүл салгаж авах боломжтой байна.</i>	708.3.1.2 motor caravan self-propelled leisure accommodation vehicle, used for touring, that meets the requirements for the construction and use of road vehicles <i>Note 1 to entry: The motor caravan is either adapted from a series production vehicle, or designed and built on an existing chassis, with or without the driving cab, the accommodation being either fixed or demountable.</i>
708.3.1.3 зөөврийн сууц шилжүүлэн байрлуулах хэрэгсэлтэй боловч авто замын тээврийн хэрэгслийн хийц ба ашиглалтын шаардлагыг хангадаггүй зөөвөрлөх боломжтой амралт, зугаалгын зориулалттай сууцны тээврийн хэрэгсэл	708.3.1.3 mobile home transportable leisure accommodation vehicle that includes means for mobility but does not meet the requirements for the construction and use of road vehicles
708.3.2 караван/майхан байрлуулах талбай амралт, зугаалгын зориулалттай сууцны тээврийн хэрэгсэл эсхүл майхан байрлуулах зориулалттай газрын хэсэг	708.3.2 caravan/tent pitch plot of ground intended to be occupied by a leisure accommodation vehicle or tent
708.3.3 караваны парк; кемпийн талбай хоёр буюу түүнээс олон караван эсхүл майхан байрлуулах талбай агуулсан газар	708.3.3 caravan park; camping park area of land that contains two or more caravan or tent pitches.
708.3.4 сууцны паркийн зөөврийн сууц үйлдвэрт үйлдвэрлэсэн, шилжүүлэн байрлуулах боломжтой сууц	708.3.4 residential park home factory-produced relocatable dwelling
708.31 Зориулалт, тэжээл ба бүтэц	708.31 Purposes, supplies and structure
708.312 Дамжуулагчийн зохион байгуулалт ба системийн газардуулга 708.312.2 Системийн газардуулгын төрөл	708.312 Conductor arrangement and system earthing 708.312.2 Types of system earthing 708.312.2.1 TN-systems

МОНГОЛ	ENGLISH
708.312.2.1 TN систем Дараахыг нэмнэ: TN системд амралт, зугаалгын зориулалттай сууцны тээврийн хэрэгсэл, майхан эсхүл сууцны паркийн зөөврийн сууцыг тэжээх төгсгөлийн хэлхээнд PEN дамжуулагч хэрэглэхгүй.	Add the following: For a TN-system, the final circuit for the supply to a leisure accommodation vehicle, tent or residential park home shall not include a PEN conductor.
708.313 Тэжээл 708.313.1 Ерөнхий зүйл 708.313.1.101 Тэжээлийн системийн хэвийн хүчдэлийг IEC 60038-аас сонгоно. Амралт, зугаалгын зориулалттай сууцны тээврийн хэрэгслийг тэжээх байгууламжийн хэвийн тэжээлийн хүчдэл нь нэг фазын хувьсах гүйдлээр 230 V ба/эсхүл гурван фазын хувьсах гүйдлээр 400 V, тогтмол гүйдлээр 48 V-оос ихгүй байна.	708.313 Supplies 708.313.1 General 708.313.1.101 The nominal supply system voltage shall be selected from IEC 60038. The nominal supply voltage of the installation for the supply of leisure accommodation vehicles shall not exceed 230 V AC single-phase and/or 400 V AC three-phase and 48 V DC.
708.4 Аюулгүй байдлын хамгаалалт 708.41 Цахилгаан гүйдэлд нэрвэгдэхээс хамгаалах 708.410.3 Ерөнхий шаардлага 708.410.3.5 Дараахыг нэмнэ: IEC 60364-4-41:2005-ын В хавсралтад заасан саад ашиглах болон гар хүрэх хүрээнээс гадуур байрлуулах хамгаалалтын аргыг хэрэглэхгүй. 708.410.3.6 Дараахыг нэмнэ: IEC 60364-4-41:2005-ын С хавсралтад заасан дамжуулахгүй байршил болон газардуулгагүй орон нутгийн эквипотенциал холболтын хамгаалалтын аргыг хэрэглэхгүй.	708.4 Protection for safety 708.41 Protection against electric shock 708.410.3 General requirements 708.410.3.5 Add the following: The protective measures of obstacles and placing out of reach as specified in Annex B of IEC 60364-4-41:2005 shall not be used. 708.410.3.6 Add the following: The protective measures of non-conducting location and earth-free local equipotential bonding as specified in Annex C of IEC 60364-4-41:2005 shall not be used.
708.415 Нэмэлт хамгаалалт 708.415.1 Үлдэгдэл гүйдлийн хамгаалах төхөөрөмж (RCD) Дараахыг нэмнэ: Розетка бүрийг 30 mA-аас ихгүй хэвийн үлдэгдэл ажиллах гүйдэлтэй RCD-ээр тус тусад нь хамгаална. Сонгосон төхөөрөмж	708.415 Additional protection 708.415.1 Residual current protective devices (RCDs) Add the following: Every socket-outlet shall be individually protected by an RCD having a rated residual operating current not exceeding 30 mA.

МОНГОЛ	ENGLISH
нь бүх хүчдэлтэй дамжуулагчийг тасална. Зөөврийн сууц эсхүл сууцны паркийн зөөврийн сууцыг суурин холболтоор тэжээх зориулалттай төгсгөлийн хэлхээ бүрийг 30 mA-аас ихгүй хэвийн үлдэгдэл ажиллах гүйдэлтэй RCD-ээр тус тусад нь хамгаална. Сонгосон төхөөрөмж нь бүх хүчдэлтэй дамжуулагчийг тасална.	Devices selected shall disconnect all live conductors. A final circuit intended for the fixed connection for a supply to a mobile home or a residential park home shall be individually protected by an RCD having a rated residual operating current not exceeding 30 mA. Devices selected shall disconnect all live conductors.
708.5 Цахилгаан тоног төхөөрөмжийг сонгох ба угсрах <i>ТАЙЛБАР – IEC TS 61439-7-э үз.</i> 708.51 Цахилгаан тоног төхөөрөмжийг сонгох ба угсрах – Нийтлэг дүрэм 708.512 Ажлын нөхцөл ба гадаад нөлөөлөл 708.512.2 Гадаад нөлөөлөл Дараахыг нэмнэ: <i>ТАЙЛБАР – Караваны парк буюу кемпийн талбайд хүний бие газрын потенциалтай шууд хүрэлцэх боломжтой, майхны гадас буюу газрын анкер утас, кабелийг гэмтээх эрсдэлтэй, мөн хүнд эсхүл өндөр тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцдог тул хүмүүс болон утас, кабелийн хамгаалалтад онцгой анхаарна.</i>	708.5 Selection and erection of electrical equipment <i>NOTE See IEC TS 61439-7.</i> 708.51 Selection and erection of electrical equipment – Common rules 708.512 Operational conditions and external influences 708.512.2 External influences Add the following: <i>NOTE In a caravan park or camping park, special consideration is given to the protection of people, due to the fact that the human body can be in contact with earth potential, to the protection of wiring due to tent pegs or ground anchors and to the movement of heavy or high vehicles.</i>
708.512.2.1.101 Ус байх (AD) Усны цацлагаас (AD4) хамгаалахын тулд тоног төхөөрөмжийг IPX4-өөс багагүй хамгаалалтын зэрэгтэйгээр сонгоно. 708.512.2.1.102 Хатуу гадны биет байх (AE) Маш жижиг биет нэвтрэхээс (AE3) хамгаалахын тулд тоног төхөөрөмжийг IP4X-өөс багагүй хамгаалалтын зэрэгтэйгээр сонгох буюу ийм хамгаалалтаар хангана. 708.512.2.1.103 Цохилт (AG) Кемпийн талбайд суурилуулсан тоног төхөөрөмжийг механик гэмтлээс (их хүчтэй AG3 цохилт) хамгаална. Тоног төхөөрөмжийн хамгаалалтыг дараах арга хэмжээний нэг буюу хэд хэдээр хангана: – урьдчилан тооцож болох аливаа	708.512.2.1.101 Presence of water (AD) Equipment shall be selected with a degree of protection of at least IPX4 in order to protect against water splashes (AD4). 708.512.2.1.102 Presence of solid foreign bodies (AE) Equipment shall be selected or provided with a degree of protection of at least IP4X in order to protect against the ingress of very small objects (AE3). 708.512.2.1.103 Impact (AG) Equipment installed in a campsite shall be protected against mechanical damage (impact of high severity AG3). Protection of the equipment shall be afforded by one or more of the following: – the position or location shall be selected to avoid damage by any reasonably foreseeable

МОНГОЛ	ENGLISH
цохилтоос гэмтэхгүй байрлал, байршлыг сонгох; – орон нутгийн буюу нийтлэг механик хамгаалалт хийх; – гадаад механик цохилтын эсрэг IK08-аас багагүй хамгаалалтын зэрэгтэй (IEC 62262-ыг үз) тоног төхөөрөмж суурилуулах.	impact; – local or general mechanical protection shall be provided; – equipment that complies with a minimum degree of protection against external mechanical impact of IK08 (see IEC 62262) shall be installed.
708.52 Утас, кабелийн систем 708.521 Утас, кабелийн системийн төрөл 708.521.7 Нэг кабель дотор хэд хэдэн хэлхээ 708.521.7.101 Караван эсхүл майхан байрлуулах талбайн тэжээл Караван эсхүл майхан байрлуулах талбайн цахилгаан тэжээлийн тоног төхөөрөмжийг тэжээхэд газар доорх түгээх хэлхээг ашиглахыг давуу гэж үзнэ. 708.521.7.102 Газар доорх кабель Нэмэлт механик хамгаалалтгүй газар доорх түгээх хэлхээг майхны гадас, газрын анкер эсхүл тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр гэмтэхээс сэргийлэх хангалттай гүнд булна. Энэ шаардлагыг хангах хамгийн бага гүнийг ерөнхийдөө 0,6 m гэж үзнэ. Эсхүл кабелийг майхны гадас буюу газрын анкер хатгаж болох талбай болон бусад бүсийн гадна суурилуулж болно. <i>ТАЙЛБАР – Газарт булсан хоолойн системийн хувьд IEC 61386-24-ийг үз.</i> 708.521.7.103 Агаарын кабель буюу агаарын тусгаарлагатай дамжуулагч Агаарын дамжуулагч бүр тусгаарлагатай байна. Агаарын утаслалтын тулгуур болон бусад даацыг тээврийн хэрэгслийн урьдчилан тооцож болох аливаа хөдөлгөөнөөр гэмтэх магадлалгүй байршилд байрлуулах буюу хамгаална. Тээврийн хэрэгсэл зорчих бүх бүсэд агаарын дамжуулагч газрын гадаргуугаас 6 m-ээс багагүй, бусад бүх бүсэд 3,5 m-ээс багагүй өндөрт байрлана.	708.52 Wiring systems 708.521 Types of wiring systems 708.521.7 Several circuits in one cable 708.521.7.101 Supply for the caravan or tent pitch The preferred method of supply for feeding the caravan pitch or tent pitch electrical supply equipment is by means of underground distribution circuits. 708.521.7.102 Underground cables An underground distribution circuit shall, unless provided with additional mechanical protection, be buried at a sufficient depth to avoid being damaged, for example by tent pegs or ground anchors or by the movement of vehicles. A depth of 0,6 m is generally considered as a minimum depth to fulfill this requirement. Alternatively the cable may be installed outside the pitch or other area where tent pegs or ground anchors may be driven. <i>NOTE For conduit systems buried underground, see IEC 61386-24.</i> 708.521.7.103 Overhead cables or overhead insulated conductors Every overhead conductor shall be insulated. Poles and other supports for overhead wiring shall be located or protected so that they are unlikely to be damaged by any foreseeable movement of vehicles. Every overhead conductor shall be at a height above ground of not less than 6 m in all areas subject to the movement of vehicles and 3,5 m in all other areas.

МОНГОЛ	ENGLISH
708.53 Тусгаарлалт, сэлгэн залгалт ба удирдлага 708.533 Хэт гүйдлээс хамгаалах төхөөрөмж Үүнээс гадна дараахыг хэрэглэнэ: Розетка бүрийг IEC 60364-4-43-ын шаардлагын дагуу хэт гүйдлийн хамгаалах төхөөрөмжөөр тус тусад нь хамгаална. Зөөврийн сууц эсхүл сууцны паркийн зөөврийн сууцыг суурин холболтоор тэжээх хэлхээг IEC 60364-4-43-ын шаардлагын дагуу хэт гүйдлийн хамгаалах төхөөрөмжөөр тус тусад нь хамгаална.	708.53 Isolation, switching and control 708.533 Devices for protection against overcurrent In addition the following applies: Every socket-outlet shall be individually protected by an overcurrent protective device, in accordance with the requirements of IEC 60364-4-43. A fixed connection for a supply to a mobile home or residential park home shall be individually protected by an overcurrent protective device, in accordance with the requirements of IEC 60364-4-43.
708.536 Тусгаарлалт ба сэлгэн залгалт 708.536.2 Тусгаарлалт 708.536.2.1 Ерөнхий зүйл 708.536.2.1.1 Дараахыг нэмнэ: Хуваарилах шүүгээ бүрд дор хаяж нэг тусгаарлах хэрэгсэл суурилуулна. Энэ төхөөрөмж нь бүх хүчдэлтэй дамжуулагчийг тасална.	708.536 Isolation and switching 708.536.2 Isolation 708.536.2.1 General 708.536.2.1.1 Add the following: At least one means of isolation shall be installed in each distribution cabinet. This device shall disconnect all live conductors.
708.55 Бусад тоног төхөөрөмж 708.55.101 Розетка 708.55.101.1 Розетка бүр IEC 60309-2-т нийцсэн байна. Розетка бүр IP44-өөс багагүй хамгаалалтын зэрэгтэй байх бөгөөд эсхүл ийм хамгаалалтыг бүрхүүлээр хангана. Хүрэх боломжтой үед розеткын контакт хүчдэлтэй байхаас сэргийлэхийн тулд розетка буюу холбогч бүр IEC 60309-2-т нийцсэн, харилцан түгжээтэй бөгөөд IEC 60309-1:1999-ийн 6.1.5-ын дагуу ангилагдсан байна, эсхүл IEC 60309-4-т нийцсэн, харилцан түгжээтэй бие даасан иж бүрэн бүтээгдэхүүний хэсэг байх бөгөөд IEC 60309-4:2006-ын 6.1.101 ба 6.1.102-ын дагуу ангилагдсан байна. 708.55.101.2 Розетка бүрийг тэжээх караван эсхүл майхан байрлуулах талбайд практик боломжийн хэрээр ойр байрлуулна. Розеткийг хуваарилах самбарт эсхүл	708.55 Other equipment 708.55.101 Socket-outlets 708.55.101.1 Every socket-outlet shall comply with IEC 60309-2. Every socket-outlet shall meet the degree of protection of at least IP44 or such protection shall be provided by an enclosure. To prevent the socket contacts being live when accessible, every socket-outlet or connector shall either comply with IEC 60309-2 and shall be interlocked and classified according to IEC 60309-1:1999, 6.1.5 or shall be part of an interlocked self-contained product complying with IEC 60309-4 and classified according to IEC 60309-4:2006, 6.1.101 and 6.1.102. 708.55.101.2 Every socket-outlet shall be located as close as practicable to the caravan pitch or tent pitch to be supplied. Socket-outlets shall be installed in the

МОНГОЛ	ENGLISH
тусдаа бүрхүүлд суурилуулна. 708.55.101.3 Урт холболтын кабелиас үүсэх аюулаас зайлсхийхийн тулд нэг бүрхүүлд дөрвөөс олон розеткийг бүлэглэж байрлуулахгүй. Розетка ашиглаж байх үед хамгаалалтын зэрэг хадгалагдах нөхцөлийг хангахын тулд нэг бүрхүүл дотор дөрвөөс олон розетка суурилуулахгүй. Сунгалтын кабель гарц, явган зам зэргийг хөндлөн гарах хэрэгцээг хамгийн бага байлгахгаар түгээх багана (шон)-ыг байрлуулбал зохино. 708.55.101.4 Караван эсхүл майхан байрлуулах талбай бүрийг дор хаяж нэг розеткаар хангана. 708.55.101.5 Розеткын хэвийн гүйдэл 16 А-аас багагүй байна. 708.55.101.6 Аливаа розеткын хамгийн доод хэсгийг газрын гадаргуугаас 0,5 м-ээс 1,5 м хүртэл өндөрт байрлуулна. Байгаль орчны онцгой хүнд нөхцөлд 1,5 м гэсэн дээрх хамгийн их өндрийг давуулахыг зөвшөөрнө. Ийм тохиолдолд залгуурыг аюулгүй залгах, салгах нөхцөлийг хангах тусгай арга хэмжээ авна. <i>ТАЙЛБАР – Караваны парк буюу кемпийн талбай үерт автах эрсдэлтэй тохиолдолд энэ шаардлага гарч болно. Мөн караваны паркийг өвлийн улиралд их хэмжээний цас орсны дараа ашигладаг бол шаардлагатай байж болно.</i>	distribution board or in separate enclosures. 708.55.101.3 In order to avoid any hazard due to long connection cables no more than four socket-outlets shall be grouped together in any one enclosure. To ensure that the degree of protection is maintained when the socket-outlets are in use, no more than four socket-outlets shall be mounted within the same enclosure. Columns (pillars) should be located so as to minimize the need for extension cables to cross gangways, etc. 708.55.101.4 Every caravan pitch or tent pitch shall be supplied with at least one socket-outlet. 708.55.101.5 The current rating of socket-outlets shall be not less than 16 A. 708.55.101.6 The lowest part of any socket-outlet shall be placed at a height between 0,5 m and 1,5 m from the ground. In special cases of extreme environmental conditions, it is permitted to exceed the stated maximum height of 1,5 m. In such cases, special measures shall be taken to ensure the safe insertion and removal of plugs. <i>NOTE This can be necessary if the caravan park or camping park risks being flooded. This can also be necessary if the caravan park is used during winter after heavy snow falls.</i>
А хавсралт (мэдээллийн) Зарим улсын тухай тайлбарын жагсаалт	Annex A (informative) List of notes concerning certain countries
708.41 Дэд зүйлийн төгсгөлд дараах тайлбарыг нэмнэ: Нэгдсэн Вант Улсад түгээгч байгууллага өөрийн хосолсон саармаг ба хамгаалах дамжуулагчийг караван буюу завины аливаа металл хийцтэй холбохыг Их Британийн хууль хориглодог (The	708.41 Add the following notes at the end of the subclause: In the United Kingdom, UK law requires that the distributor shall not connect his combined neutral and protective conductor to any metalwork in a caravan or boat (Regulation 9(4) of The Electricity Safety, Quality and

МОНГОЛ	ENGLISH
Electricity Safety, Quality and Continuity Regulations 2002 No. 2665-ын 9(4) дүгээр зохицуулалт).	Continuity Regulations 2002 No. 2665).
708.512.2.1.103 Дэд зүйлийн төгсгөлд дараах тайлбарыг нэмнэ: ТАЙЛБАР – АНУ-д ухарч байрладаг талбайд караваны талбайн цахилгаан тэжээлийн тоног төхөөрөмжийг зогсоосон тээврийн хэрэгслийн зүүн (замын буюу жолоочийн) талд, талбайн зүүн захаас (зогсоосон RV-ийн жолоочийн талаас) 1,5 м-ээс 2,1 м (5 ft-ээс 7 ft) зайтай шугам дээр, талбайн арын захаас эхлэн урагш 4,5 м (15 ft) хүртэлх шугамын аль нэг цэгт байрлуулна. Нэвт гардаг талбайн хувьд цахилгаан тэжээлийн тоног төхөөрөмжийг зогсоосон RV-ийн жолоочийн талын зүүн захаас 1,5 м-ээс 2,1 м (5 ft-ээс 7 ft) зайтай шугамын дагуу, талбайн арын захаас урагш 4,9 м (16 ft)-ээс эхлэн хоёр нэвтрэх замын хоорондох төв цэг хүртэлх аль нэг цэгт байрлуулахыг зөвшөөрнө. Талбайн зүүн захыг (зогсоосон RV-ийн жолоочийн тал) тэмдэглэсэн байна. Талбайн тэжээлийн бүх тоног төхөөрөмжид 600 mm (2 ft)-ээс багагүй өргөн, 2,0 м (6 ft 6 in.)-ээс багагүй өндөр саадгүй орц буюу гарцаар хүрэх боломжтой байна.	708.512.2.1.103 Add the following note at the end of the subclause: NOTE In the United States, where provided on back-in sites, the caravan vehicle site electrical supply equipment shall be located on the left (road or driver) side of the parked vehicle, on a line that is 1,5 m to 2,1 m (5 ft to 7 ft) from the left edge (driver's side of the parked RV) of the stand and shall be located at any point on this line from the rear of the stand to 4,5 m (15 ft) forward of the rear of the stand. For pull-through sites, the electrical supply equipment shall be permitted to be located at any point along the line that is 1,5 m to 2,1 m (5 ft to 7 ft) from the left edge (driver's side of the parked RV) from 4,9 m (16 ft) forward of the rear of the stand to the centre point between the two access roads. The left edge (driver's side of the parked RV) of the stand shall be marked. All site supply equipment shall be accessible by an unobstructed entrance or passageway not less than 600 mm (2 ft) wide and 2,0 m (6 ft 6 in.) high.
708.521.7.102 Дэд зүйлийн төгсгөлд дараах тайлбаруудыг нэмнэ: ТАЙЛБАР 2 – Чех болон Словак улсад механик хамгаалалтгүй кабелийг булшлах шаардагдах хамгийн бага гүн 0,7 м (кабелийн дээр 0,2 м-ээс 0,3 м зайд анхааруулах туузтай) байна. ТАЙЛБАР 3 – Финланд болон Исландад газар доорх кабелийг дор хаяж 0,7 м гүнд булна; нэмэлт механик хамгаалалттай бол гүн нь дор хаяж 0,5 м байна. ТАЙЛБАР 4 – Япон болон Швейцарт энэ шаардлагыг хангах хамгийн бага гүнийг 0,6 м гэж үзнэ. ТАЙЛБАР 5 – Канадад механик хамгаалалтгүй кабелийг булшлах	708.521.7.102 Add the following notes at the end of the subclause: NOTE 2 In the Czech Republic and Slovakia the minimum required depth of burying non-mechanically protected cables is 0,7 m (with a warning strip 0,2 m to 0,3 m above the cable). NOTE 3 In Finland and Iceland, underground cables shall be buried at a depth of at least 0,7 m, unless such cables have additional mechanical protection, in which case the depth shall be at least 0,5 m. NOTE 4 In Japan and Switzerland a depth of 0,6 m is considered as a minimum depth to fulfill this requirement. NOTE 5 In Canada the minimum required

МОНГОЛ	ENGLISH
шаардагдах хамгийн бага гүн 0,6 м (кабелийн дээр ойролцоогоор 0,15 м зайд анхааруулах туузтай) байна. ТАЙЛБАР 6 – Ирландад хамгийн бага гүн 500 mm, харин хүнд тээврийн хэрэгсэл хөдөлгөөнтэй газарт 750 mm байна.	depth of burying non-mechanically protected cables is 0,6 m (with a warning stripe at approximately 0,15 m above the cable). NOTE 6 In Ireland, a minimum depth of 500 mm is required, and 750mm where there is movement of heavy vehicles.
708.521.7.103 Дэд зүйлийн төгсгөлд дараах тайлбаруудыг нэмнэ: ТАЙЛБАР 1 – Шведэд агаарын дамжуулагчийн хамгийн бага өндөр 4,5 м байна. ТАЙЛБАР 2 – Финланд болон Японд бусад бүх бүсэд агаарын дамжуулагч газрын гадаргуугаас 4 м-ээс багагүй өндөрт байрлана. ТАЙЛБАР 3 – Исландад тээврийн хэрэгсэл хөдөлгөөнтэй бүх бүсэд агаарын дамжуулагч газрын гадаргуугаас 6 м-ээс багагүй, бусад бүх бүсэд 4,5 м-ээс багагүй өндөрт байрлана. ТАЙЛБАР 4 – Ирландад караваны паркийн бүх хэсэгт хамгийн бага өндөр 6 м байна. ТАЙЛБАР 5 – Ирландад дамжуулагчийг аливаа караван байрлуулах талбайн хилээс 2 м-ээс багагүй зайд гадна байрлуулна.	708.521.7.103 Add the following notes at the end of the subclause: NOTE 1 In Sweden, the minimum height for overhead conductors is 4,5 m. NOTE 2 In Finland and Japan, overhead conductors shall be at a height above ground of not less than 4 m in all other areas. NOTE 3 In Iceland, every overhead conductor shall be at a height above the ground of not less than 6 m in all areas subject to movement of vehicles and 4,5 m in all other areas. NOTE 4 In Ireland, a minimum height of 6 m is required throughout a caravan park. NOTE 5 In Ireland, they (conductors) shall be located at a minimum distance of 2 m outside the boundary of any caravan pitch.
708.536.2.1.1 Дэд зүйлийн төгсгөлд дараах тайлбарыг нэмнэ: ТАЙЛБАР – АНУ-д хуваарилах шүүгээ бүрд нэг тусгаарлах сэлгэн залгах төхөөрөмж суурилуулна. Энэ төхөөрөмж нь саармаг дамжуулагчийг оролцуулан шүүгээнд орж буй бүх хүчдэлтэй дамжуулагчийг тасална. Дөрвөөс олонгүй розетка тутамд нэг тусгаарлах сэлгэн залгах төхөөрөмж суурилуулна.	708.536.2.1.1 Add the following note at the end of the subclause: NOTE In the United States, one isolating switching device shall be installed in each distribution cabinet. This switching device shall disconnect all live conductors, entering the cabinet, including the neutral conductor. One isolating switching device shall be installed for a maximum of every four socket-outlets.
708.55.101.1 Эхний догол мөрийн дараа дараах тайлбарыг нэмнэ: ТАЙЛБАР – Канад болон АНУ-д бусад стандартын дагуу 120 V эсхүл 120 V-оос 260 V хүртэл хэвийн хүчдэлтэй розетка хэрэглэдэг.	708.55.101.1 Add the following note after the first paragraph: NOTE In Canada and the United States, socket-outlets rated 120 V or 120 V to 260 V according to other standards are used.
НОМ ЗҮЙ	Bibliography

MNS IEC 60364-7-708:20XX

МОНГОЛ	ENGLISH
IEC 60364-7-721, Нам хүчдэлийн цахилгаан байгууламж – 7-721 дүгээр хэсэг: Тусгай байгууламж буюу байршилд тавих шаардлага – Караван болон авто караваны цахилгаан байгууламж IEC 61386-24, Кабель удирдлагын хоолойн систем – 24 дүгээр хэсэг: Тусгай шаардлага – Газарт булсан хоолойн систем IEC TS 61439-7, Нам хүчдэлийн таслах, залгах болон удирдлагын аппаратын иж бүрдэл – 7 дугаар хэсэг: Марина, кемпийн талбай, захын талбай, цахилгаан тээврийн хэрэгслийн цэнэглэх станц зэрэг тусгай хэрэглээний иж бүрдэл	IEC 60364-7-721, Low voltage electrical installations – Part 7-721: Requirements for special installations or locations – Electrical installations in caravans and motor caravans IEC 61386-24, Conduit systems for cable management – Part 24: Particular requirements – Conduit systems buried underground IEC TS 61439-7, Low-voltage switchgear and controlgear assemblies – Part 7: Assemblies for specific applications such as marinas, camping sites, market squares, electric vehicles charging stations